



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 101

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Концессын тухай хуулийн 2.4 дэх заалт, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар, Концессын “барих-шилжүүлэх” төрлөөр 2016-2019 онд хэрэгжиж, ашиглалтад оруулсан, нийт 84,726,998,861.78 (наян дөрвөн тэрбум долоон зуун хорин зургаан сая есөн зуун ерэн найман мянга найман зуун жаран нэгэн төгрөг далан найман мөнгө) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу холбогдох аймаг, нийслэлийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан, Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ц.Идэрмөнх, Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга С.Баясгалан, Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Б.Болд, Ховд аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ш.Нохойжав, Сэлэнгэ аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга П.Эрдэнэсайхан, Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын дарга Ш.Үнэнбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, эзэмшигч байгууллагыг тогтоох асуудлыг шийдвэрлүүлэх;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ 000002

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 5 дугаар сарын 3 ны өдрийн 107 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР КОНЦЕССИЙН "БАРИХ-ШИЛЖҮҮЛЭХ" ТӨРЛӨӨР БИЙ БОЛСОН АЙМАГ НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Концессын зүйлийн нэр	Концесс эзэмшигч (эргэн төлөлтийн санхүүжилт авсан)	Гэрээний дүн (төгрөгөөр)	Даясны ҮНЭ		Бүртгэх аймгийн нэр
				Гүйцэтгэлээр	(төгрөгөөр)	
1	Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 6-р цэцэрлэгийн 100 хүүхдийн өргөтгөлийн барилга	Зүүншанд ХХК	1,154,035,551.0	1,094,523,417.0		Баянхонгор
2	Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Баян-Ойт 1-р цэцэрлэгийн 100 ортой өргөтгөлийн барилга	Зүүншанд ХХК	1,154,035,551.0	1,136,088,741.0		Баянхонгор
3	Баянхонгор аймгийн Богд суманд баригдах 50 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөл барилга	Жишиг бетон ХХК	738,246,207.0	705,400,165.0		Баянхонгор
4	Баянхонгор аймгийн Шаргалжуут тосгонд баригдах 75 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөл барилга	Очир заан ХХК	1,029,917,704.0	994,990,000.0		Баянхонгор
5	Дархан-Уул аймаг, Дархан сум, 5-р баг, Жигүүр цогцолбор сургуулийн хашаанд цэцэрлэгийн барилга	Жинсийн орой ХХК	1,386,589,000.0	1,385,700,300.0		Дархан-Уул
6	Хөвсгөл, Жаргалант сум цэцэрлэгийн барилга	Хөвсгөл чандмань ХХК	2,050,346,111.0	2,050,346,111.0		Хөвсгөл
7	Хөвсгөл, Шинэ-Идэр сум, цэцэрлэгийн барилга	Хөвсгөл геологи ХХК	2,357,857,567.0	2,297,616,385.0		Хөвсгөл
8	Хөвсгөл, Цагаан-Уул сум, 150 ортой цэцэрлэгийн барилга	Хөвсгөл геологи ХХК	2,806,617,681.0	2,766,188,224.0		Хөвсгөл
9	Хөвсгөл аймгийн Тариалан сум, Соёл, спортын цогцолборын барилга	Идэр чандмань ХХК	3,616,539,040.0	3,616,500,000.0		Хөвсгөл
10	Хөвсгөл, Цагаан-Уул сум, сургуулийн барилга	Хөвсгөл геологи ХХК	6,116,389,381.0	5,864,306,903.0		Хөвд
11	Хөвд, Жаргалант сум, 1 дүгээр цэцэрлэгийн барилга	"Улаан Дөл" ХХК	2,105,741,568.0	2,105,651,568.0		Хөвд
12	Сургуулийн барилгын өргөтгөл /УБ, БЗД, 14 дүгээр сургууль/	Цамхаг констракшн ХХК	10,787,000,000.0	10,762,876,309.0		Нийслэл
13	Сургуулийн барилга / УБ, БГД, 38 дугаар сургууль/	ӨВМТХ ХХК	14,657,300,000.0	17,245,200,000.0		Нийслэл
14	Сургуулийн барилга /УБ, БГД, 73 дугаар сургууль/	Монкон контракшн ХХК	10,709,633,450.0	10,687,607,034.78		Нийслэл
15	Сургуулийн барилга /УБ, ХУД, 32 дугаар сургууль/	Ганьт ХХК	5,800,000,000.0	5,800,000,000.0		Нийслэл
16	Сэлэнгэ аймгийн Түнхэл тосгон дахь гүүрийн барилгын ажил	ЗМЗ ХХК	1,949,888,978.0	1,904,921,654.0		Сэлэнгэ
17	Хөвсгөл аймгийн Идэрийн голын хөвдөг гүүр	Урагшлах ХХК	787,500,000.0	767,400,000.0		Хөвсгөл
18	Мандал сум Зүүн Хараа чиглэлийн 15.8 км хатуу хучилттай авто зам төсөл	Замын битум ХХК	13,141,682,050.0	13,141,682,050.0		Сэлэнгэ
19	Алтанбулаг сумыг цэвэр усны эх үүсвэртэй холбох	Маргад Монгол ХХК	400,000,000.0	400,000,000.0		Сэлэнгэ
				82,749,319,839.0	84,726,998,861.8	
Нийт дүн			(наян хоёр тэрбум долоон зуун дөчин есөн сая гурван зуун арван есөн мянга найман зуун гучин есөн төгрөг)	(наян дөрвөн тэрбум долоон зуун хорин зургаан сая есөн зуун ерэн найман мянга найман зуун жаран нэгэн төгрөг найман мөнгө)		